2019-10-22

НҮБ-ЫН НЭН БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ, ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ БОЛОН АРЛЫН ЖИЖИГ ОРНУУДЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭЭД ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР “ДАЛАЙД ГАРЦГҮЙ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДАД ДАМЖИН ӨНГӨРӨХ ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛААРХ” ОЛОН УЛСЫН ХУРЛЫН ИЛТГЭЛ

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид,
Хүндэт хадагтай, ноёд оо,

Юуны өмнө Монгол Улсын ЗТХЯ-ны нэрийн өмнөөс НҮБ-ын Нэн буурай

- “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд өртөө хооронд төмөр замын дохиоллын системийг шинэчлэх ажил хийгдээд дуусч байна /2016-2019 он/;
- “УБТЗ” ХНН-ийн Зүүнхараа дахь ачааны вагон депогийн өргөтгөлийн ажил хийж ашиглалтад оруулсан. /2017-2019 он/;
- Төмөр замын дэд бүтцийн шинэчлэлийн ажил /Р65 зам төмөр, төмөр бетон дэртэй, 30-35 см зузаан балласт/ /2016-2019 он/

Авто замын Төв коридорын шинэчлэлийн ажлууд:

- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэх хугацаа 2019-2020 он;
- Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,6 км авто замыг 4 эгнээтэй болгон өргөтгөж, шинэчлэх ажлыг хэрэгжүүлж байна. /2019 оноос эхэлсэн/

Орон орны төлөөлөгчид, олон улсын байгууллагууд болон хөрөнгө оруулагчид хамтран зам, тээврийн салбарт оруулах өөрсдийн хувь нэмэр, нөөц бололцоо, боломж, чадамжийн талаар өргөн хүрээнд үр дүнтэй хэлэлцэнэ гэдэгт итгэлтэй байна.

Ази, Европыг холбох гүүр болсон Монгол Улс нь бусад улс орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд хүчин чармайлт гарган, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэл дүүрэн байгааг дуулгахад таатай байна.

Энэхүү өндөр ач холбогдолтой энэхүү хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.